



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2018 оны 08 сарын 13 өдөр

Дугаар А/Б/3

Улаанбаатар хот

Инженерийн баг, хяналтын  
инженер томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Иргэний нисэхийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.7 дахь заалт, ИНД-171.79.(а) 6.2 “Байгууламжийг суурилуулах ба ажилд хүлээн авах журам”-ын 6.2.4.1, 6.2.6.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өмнөговь аймгийн Мандал-овоо сумын Баянтээг, Хөвсгөл аймгийн Түнэл сумын Хэнгэрэгтэй, Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Их-Өлгий, Хэнтий аймгийн Чингис хаан хотын нисэх буудал, Дорноговь аймгийн Сайншанд сумын Сайншанд объектуудад байршилтай автомат хамааралтай ажиглалтын системүүдэд /ADS-B/ тасралтгүй тэжээлийн төхөөрөмжүүдийг /UPS 3kVa/ 2018 оны 8 дугаар сарын 14-ний өдрөөс 8 дугаар сарын 31-ний өдрийн хооронд суурилуулж гүйцэтгэх инженерийн баг, хяналтын инженерийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Инженерийн багийн

ахлагч:

Э.Оргил

Холбоо, навигаци, ажиглалтын албаны Ажиглалт автоматжуулалтын хэсгийн Техник ашиглалтын тасгийн инженер

Гишүүд:

Б.Золбаяр

Холбоо, навигаци, ажиглалтын албаны Ажиглалт автоматжуулалтын хэсгийн Техник ашиглалтын тасгийн инженер

О.Төрболд

Холбоо, навигаци, ажиглалтын албаны Холбооны хэсгийн Радио холбооны тасгийн инженер

Э.Даваасаамбуу

Холбоо, навигаци, ажиглалтын албаны Холбооны хэсгийн Радио холбооны тасгийн инженер

Н.Цогбаяр

Холбоо, навигаци, ажиглалтын албаны Холбооны хэсгийн Радио холбооны тасгийн инженер

	С.Билгүүн	Холбоо, навигаци, ажиглалтын албаны Холбооны хэсгийн Мэдээллийн технологийн тасгийн инженер
	Г.Нандин-Эрдэнэ	Холбоо, навигаци, ажиглалтын албаны Холбооны хэсгийн Мэдээллийн технологийн тасгийн инженер
Хяналтын инженер:	Д.Доржмягмар	Холбоо, навигаци, ажиглалтын албаны Ажиглалт автоматжуулалтын хэсгийн Техник ашиглалтын тасгийн ахлагч инженер

2. Тоног төхөөрөмжийг суурилуулах, туршилтын ажлыг агаарын навигацийн үйлчилгээний байгууламжуудын хэвийн ажиллагаанд сэргөөр нөлөөлөхгүйгээр нислэгийн аюулгүй ажиллагааг бүрэн хангаж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгааг мөрдөн ажиллаж, зохих журмын дагуу удирдлагад тайлагнахыг инженерийн багийн ахлагч /Э.Оргил/-д үүрэг болгосугай.

3. Суурилуулалтын ажлын явц болон гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Холбоо, навигаци, ажиглалтын алба /Д.Баяртогтох/-нд үүрэг болгосугай.

ДАРГА



Л.БЯМБАСҮРЭН